



Хэвлэлийн мэдээ

2016 оны 3-р сарын 16-ны өдөр, Лхагва гараг

Холбогдох утас:

9710-9009

**Монгол дахь Америкийн Худалдааны Танхим
Монгол улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэгтэй
уулзалт зохион байгууллаа**

Улаанбаатар хот, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхимын (АмЧам Монгол) 2016 оны 3-р сарын 16-нд зохион байгуулсан ээлжит уулзалтад Монгол Улсын Ерөнхий Сайд Ч.Сайханбилэг оролцлоо. Монгол улсын Засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэл болон Монгол улсын эдийн засгийн дунд хугацааны төлөв байдлын талаар Ерөнхий сайдаас сонсохоор гадаад болон дотоодын 100 гаруй компанийн төлөөлөгчид хуран цуглав.

Ерөнхий сайд Ч.Сайханбилэг ийнхүү өнгөрсөн 12 сарын хугацаанд гурав дахь удаагаа АмЧам Монгол байгууллагын уулзалтад уригдан оролцож байгаа юм. Ерөнхий сайд хэлсэн үгэндээ “АмЧам Монгол байгууллагатай жил болгон уулзаж ярилцдаг сайхан уламжлал тогтоод байгаа билээ. Би та бүхэнтэй бизнес эрхлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл тэдгээрийг хамтдаа хэрхэн шийдвэрлэх талаар харилцан ярилцахыг хүсч байна” гэв.

Мөн тэрээр Засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэлийн талаар хэлэхдээ “Монгол улсын Засгийн газар эдийн засгийн шинэчлэлийг үргэлжлүүлэх, авлигалтай тэмцэхэд өндөр ач холбогдол өгч ажиллаж байгаа” гэсэн юм. АмЧам Монголын ТУЗ-ийн дэд дарга ноён Г.Магнай арга хэмжээний нээлтийн үгэндээ Ерөнхий сайдад хандан “АмЧам Монгол болон манай гишүүд чөлөөт зах зээлийг хөгжүүлэх, бизнесийн орчинг таатай болгож ажлын байр болон хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр тантай хамтран ажиллахыг хүсч байна” гэсэн юм.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хооронд бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбарын статустай. Вашингтон ДиСид байрладаг Америкийн Худалдааны Танхим нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.